



Түр хорооны хуралдааны тэмдэглэл
2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-13
<i>1.Хүний эрх, жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний санал, зөвлөмжийг хэлэлцэх</i>	4-13

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хүний эрхийн дэд хорооны 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 9 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 27 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганбат;

Чөлөөтэй: Ш.Раднаасэд.

***Нэг.Хүний эрх, жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний санал,
зөвлөмжийг хэлэлцэх***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан, Х.Мөнхзул, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, “Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо”-ны тэргүүн, НҮБ-ын 11:40 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны гишүүн Д.Гэрэл, Хүний эрхийн шинжээч Б.Болорсайхан, Жендэрийн үндэсний зөвлөх Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч, социологийн доктор, дэд профессор М.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн асан, Жендэрийн үндэсний хорооны шинжээч Б.Долгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал байлцав.

Хүний эрхийн асуудлаарх санал, зөвлөмжийг Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн шинжээч Б.Болорсайхан, жендерийн асуудлаарх санал, зөвлөмжийг Хүний эрхийн Үндэсний Комиссын Жендэрийн үндэсний хорооны шинжээч Б.Долгор нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн шинжээч Б.Болорсайхан, мөн Комиссын Жендэрийн үндэсний хорооны шинжээч Б.Долгор нар хариулж, тайлбар хийв.

“Санал зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Дэд хорооны тогтоолын төслийг Дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар үг хэлэв.

Ц.Мөнхцэцэг: “Санал зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Дэд хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 1

Бүгд: 6

83.3 хувийн саналаар Дэд хорооны тогтоол батлагдлаа.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 44 минут үргэлжилж, 9 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД

ХОРООНЫ ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ

АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн
хууль” танхим 14 цаг 27 минут

**ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Мөнхцэцэг: Хүний эрхийн дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хүний эрхийн дэд хорооны 2024 оны 1 сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хүний эрхийн дэд хорооны гишүүн Ширнэнбаньдын Адьяаа гишүүн ирсэн байна. Норовын Алтанхуяг гишүүн ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн ирсэн байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн байна. Мөн Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн ирсэн байна аа.

Ингээд ирц бүрэлдсэн байна. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Хүний эрх, жендерийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний санал зөвлөмжийг өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуулттай холбоотой саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

Хүний эрх жендерийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний санал зөвлөмжийг хэлэлцье.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтныг танилцуулъя.

Ц.Батбаатар Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Агар-Эрдэнэ Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга, ХЭҮК-оос Ж.Хунан ХЭҮК-ын гишүүн, Мөнхзул, ХЭҮК-ын гишүүн, Адъяахишиг ХЭҮК-ын Тамгын газрын дарга, Хүний эрхийн Үндэсний зөвлөхүүдээс Д.Гэрэл Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны тэргүүн, НҮБ-ын 1140 Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн хорооны гишүүн, Болорсайхан Хүний эрхийн шинжээч, Жендерийн үндэсний зөвлөх Батбаатар, МУИС-ийн шинжлэх ухааны сургуулийн Социологи нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч, социологийн ухааны доктор, дэд профессор, Долгор Улсын Их Хурлын гишүүн асан, Жендерийн үндэсний хорооны шинжээч.

Монгол Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрүүдэд Олон улсын парламентын холбоотой хамтран хүний эрх жендерийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээг зохион байгуулсан.

Уг өөрийн үнэлгээний хүрээнд хараат бус бие даасан үндэсний зөвлөхүүд ажиллаж хүний эрх жендерийн асуудлаар парламентад түүний Тамгын газраас авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар санал зөвлөмжүүдийг боловсруулан гаргасныг танилцуулж байна аа.

Ингээд хүний эрхийн асуудлаар санал зөвлөмжийг Хүний эрхийн Үндэсний Зөвлөх Болорсайхан танилцуулна.

Ингээд ажлын хэсгийн 3 дугаар микрофон нээхийг урьж байна.

Б.Болорсайхан: Сайн байцаана уу? Хүний эрхийн Үндэсний Зөвлөх Болорсайхан, Гэрэл нарын хамтран боловсруулсан нийт 36 зөвлөмж байгаа. Нэгдүгээр багц зөвлөмж нь 19 зөвлөмж байгаа бөгөөд хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагаанд анхаарах чиглэлээр дараах зөвлөмжийг боловсруулсан. Монгол Улсын Их Хурлын зүгээс тухайлан үүрэг хүлээсэн албан ёсны бүтэц бий болгох зорилгоор Хүний эрхийн байнгын хороо түүн дотор Жендэрийн дэд хороо, Тогтвортой хөгжлийн дэд хороог байгуулж ажиллах нь зүйтэй юм байна аа. Ялангуяа эрх тэгш байдлыг хангах үйл ялгаварлах гэдэг бол үндсэн зарчим, хүний эрхийн агуулга дор байнга яригддаг учраас ийнхүү байгуулах нь зүйтэй.

Хууль зүйн байнгын хорооноос хариуцсан чиглэлийг нь зааглаж ялгахын тулд хүний эрх, эрх чөлөөг хангах, эдлэхүйц таатай нөхцөл боломжийг тодорхойлох НҮБ-ын хүний эрхийн механизмд, парламент хамтын оролцоог хангах, төлөөлөх, жендерийн эрх тэгш байдал, тогтвортой хөгжил зэрэг үл ялгаварлах эрх тэгш байх зарчмын хүрээнд хөгжих эрхийн асуудлыг Хүний эрхийн байнгын хороонд хариуцуулах нь зүйтэй юм байна гэж үзсэн.

Мөн хүний эрхийн Байнгын хороо жил бүр хүний эрхийн үндэсний байгууллагуудын Дэлхийн Ассамблейн магадлан итгэмжлэх дэд хорооны зөвлөмжийн хэрэгжилт мөн Хүний эрхийн үндэсний байгууллага нь

Парисын зарчимд нийцэн ажиллаж байгаа талаар сонсгол хийдэг байх нь зүйтэй юм байна.

Үүгээр дамжуулаад парламентын хяналтыг сайжруулахын зэрэгцээ холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх, засаж сайжруулахад нэмж өөрчлөхөд чухал хувь нэмэртэй гэж харж байгаа. Үүний зэрэгцээгээр олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргээ төрийн байгууллага биелүүлэхүйц төсвийг хангалттай хүрэлцэхүйц хэмжээгээр хуваарилахын зэрэгцээ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар холбогдох шаардлагатай, арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй юм байна.

Мөн үүн дээр Хүний эрхийн Үндэсний Комисс бас оройлон ажиллах нь зүйтэй юм байна гэж харж байгаа. Тэгээд эрхэм гишүүдийн та бүхний өмнө Улсын Их Хурлын Тамгын газраас боловсруулж бэлдсэн хүний эрх жендерийн асуудлаарх Парламентын өөрийн үнэлгээ, үйл ажиллагааны тайлан болон санал зөвлөмж байна. Миний танилцуулсан санал зөвлөмж маань 7 дугаар нүүрнээс эхэлж байгаа. Эхний 1-ээс 14 дэх зөвлөмж бол үндсэндээ хүний эрхийн мэдрэмжтэй парламентыг бэхжүүлж ажиллах талаарх зөвлөхийн зүгээс өгч байгаа зөвлөмж.

Хоёрт нь яригдаж байгаа зүйл бол парламентын хяналтыг бэхжүүлэх хүрээнд ХЭҮК-ын жил бүр хүргүүлдэг илтгэлийг тухайн жилийн 4 дүгээр сард багтаан Улсын Их Хурал хэлэлцэж холбогдох тогтоолоо баталж хэвших бүтцийн болон тогтолцооны шинжтэй хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх тухай тогтоол гаргах бол түүн дотроо заавал 12-24 сарын товоо тогтоодог байх нь зүйтэй. Илүү үр дүнтэй, оновчтой гэж зөвлөхүүдийн зүгээс үзэж байна.

Мөн Хууль зүйн байнгын хороо бусад Улсын Их Хурлын Тамгын газар хамтран олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай үр дагаварт үнэлгээ, 2024 оны 1 дүгээр улиралд багтаан хийж танилцуулахыг даалгах, мөн өмнө нь Хууль зүйн байнгын хорооны байгуулсан ажлын хэсгийн тухайлан хариуцаж ажиллаж байгаа олон улсын гэрээний үүргийн хэрэгжилтийн талаарх тайлангийн мөрөөр Засгийн газар зарцуулж хүний эрхийн механизмын зөвлөмжийг хэрэгжүүлэх төсвийг тооцоолон яг үүрэг хүлээж байгаа холбогдох төрийн байгууллагуудад хамтатгалтай хэмжээгээр Улсын Их Хурал хуваарилах нь зүйтэй гэж харж байгаа. Мөн Хүний эрхийг хангах Үндэсний хорооны санаачилга шийдвэрийн дагуу Хүний эрхийн Үндэсний Комисс манлайлан боловсруулсан Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний 2024-2034 оны төлөвлөгөө, хөтөлбөрийг хэлэлцэн батлах, жил бүр хүний эрхийн Байнгын хороогоор хэрэгжилтийг хэлэлцэж хэвших нь оновчтой.

Улсын Их Хурлын Тамгын газрын алба хаагчдын тоог нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, мэргэших, чадавхжих асуудлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн шинэчлэх ухаанч байдлаар ажиллах нөхцөл бүрдүүлэх нь зүйтэй гэж онцолсон байгаа.

Дараагийн танилцуулах 20-оос 25 дугаар зөвлөмж маань үндсэндээ НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд парламентын оролцоог нэмэгдүүлэх агуулгаар боловсруулсан. Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо олон талын төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэйгээр өмнө дурдсан Хууль зүйн байнгын хорооны олон улсын гэрээний үүргийн хэрэгжилтийн талаарх ажлын хэсгийн тайланг үр дүнтэй танилцуулж Хууль зүйн байнгын хороогоор уламжлан

нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй юм байна гэж зөвлөж байна.

Мөн нэгдсэн хуралдаанаас НҮБ-ын хүний эрхийн механизмын зөвлөмжийг, хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоол гаргуулж Засгийн газраас ихэнх хариуцлагыг нэмэгдүүлэх нь оновчтой гэж үзэж байна.

Мөн олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Улсын Их Хурлын хүний эрхийн байнгын хороо шаардлагатай тохиолдолд асуудал хамаарсан холбогдох байнгын хороодоор хүний эрхийн гэрээний хэрэгжилтийн тайлан төсөл хэлэлцдэг байвал зохино гэж онцолж байгаа. Монгол Улсын Засгийн газар Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн тайлан, сайн дурын үндэсний илтгэлийг Хүний эрхийн байнгын хорооны Тогтвортой хөгжлийн дэд хороогоор хэлэлцэж, Засгийн газрын хэлэлцүүлгийн мөрөөр НҮБ-д илгээж хэвших, Засгийн газраас Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын зарим гэрээ конвенцын цөөнгүй нэр томъёоны монгол орчуулгыг эргэн хянах боломжит хүрээнд оновчтой болохыг шаардах зөвлөмжийг тусгасан. Мөн Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүргээ биелүүлж нэгдэн орсон гэрээдийн ерөнхий тайлбар, илгээсэн тайлан мэдээ, түүний дагуу хүлээн авсан дүгнэлт, зөвлөмж, ажиглалт нэг бүрийг албан ёсоор Монгол хэлнээ орчуулж хэрэглээнд нэвтрүүлэх төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэх эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем легал инфогоор түгээхийг шаардах гэж зөвлөж байна.

4 дэх багц санал зөвлөмж маань олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд талуудыг татан оролцуулж 26-аас 36 дахь та бүхэнд

тараасан материалын зөвлөмжийг өгсөн байгаа.

Энэ дээр иргэд, олон нийт, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд Төрийн ордонд нэвтрэхэд шаардаж байгаа ялгаварлан гадуурхалтын шинжтэй хувцасны шалгуурыг холбогдох журмаас хасах. Байнгын хороо, дэд хороо, ажлын хэсгийн хэлэлцүүлгийн чуулганы хуралдааны бичлэгийг хэл үг хэлж байгаа хүний дүрсээр хязгаарлахгүй. Танхимын дүрс бичлэгийг бүхэлд нь тусгайлан дамжуулж хэвших, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд зураг, дүрс авах боломжоор тэгш хангах, Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, ЗГХЭГ-ын зүгээс Төрийн ордонд ажиллаж байгаа албан хаагчдад зориулсан холбогдох нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг батлах, НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэгш хамруулах, оролцоог дэмжих стратегиас үлгэрлэн Улсын Их Хурал болон Засгийн газарт зориулсан үлгэрчилсэн журам хариуцан гүн гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, аливаа хууль тогтоомжийн төсөл боловсруулах парламент хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулж байгаа сонсгол хэлэлцүүлэг гэх мэт үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад орхигдох магадлалтай бүлгүүдийн эрхийг хамгаалах чиглэлд ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог тэгш хангах зорилгоор тэдгээр байгууллагуудын жагсаалт сан бүрдүүлж, тэдний оролцоог бодитой, үр дүнтэй, утга учиртай хангаж ажиллах нь зүйтэй юм байна гэж үзсэн.

Эдгээр зөвлөмжийг бодит үйл хэрэг болгоход туслан дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг шууд бодитой шинэчлэн үздэг болгох, Төрийн ордны барилга байгууламжийн саадгүй байдал, хүртээмжийн талаарх үнэлгээг мэргэшсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран хийх, үнэлгээний мөрөөр цаашид түгээмэл загварын дагуу парламентын орчныг цогцоор, нээлттэй, таатай орчин болгох зорилгоор хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллах, Улсын Их Хурлын мэдээлэл түгээх олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтнуудад хүртээмжтэй мэдээллийн талаар сургалт зохион байгуулах, Парламентын сургалт судалгааны хүрээлэн сар бүр сүүлийн лхагва гарагт хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн шинжээч, хүний эрх хамгаалагч, төрийн болон төрийн бус байгууллагууд оролцсон дугуй ширээний цахим уулзалт зохион байгуулж хүний эрхийн тулгамдсан асуудлын талаар хэлэлцэх, харилцах, мэдээлэл солилцох суваг болгож ажиллуулах, Комиссын зүгээс Хүний эрхийн үндэсний байгууллагын хувиар Парламентын сургалт судалгааны хүрээлэн сар бүр сүүлийн лхагва гарагт зохион байгуулах дугуй ширээний цахим уулзалтад Иргэний нийгмийн зөвлөл Хүний эрх хамгаалагчийн хамгаалах хорооны мэдээллийг хуваалцаж хэвших гэдэг зөвлөмжийг боловсруулж, танилцуулж байна аа. Баярлалаа.

Ц.Мөнхцэцэг: Үндэсний зөвлөх Болорсайхан танд баярлалаа.

Дараагийн сэдэв буюу одоо жендерийн чиглэлээрх санал зөвлөмжийг Жендэрийн үндэсний зөвлөх Долгор та танилцуулна уу?

Б.Долгор: Сайн байцаана уу? Тэгэхээр жендерийн чиглэлээр санал, зөвлөмж маань 4 хүрээнд гарсан байгаа.

Нэгдүгээрх нь бол парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх чиглэлээр хийх асуудлын талаар.

Ер нь зөвлөмж маань нэлээн олон зөвлөмжүүд өгөгдсөн байгаа. Тэрнээс товчхон байдлаар танилцуулъя гэж бодож байна.

Тэгэхээр 1 дүгээрт улс төрийн намын болон Улсын Их Хурлын ба орон нутгийн сонгуулийн тогтолцоо, албан тушаалын томилгоо, нэр дэвшилтийн мөнгөнөөс хараат байдлыг зогсоож хөрөнгөлөг хүмүүс голчлон сонгогдож байгаа нөхцөлийг өөрчлөх ёс зүйн өндөр шалгуурыг хуульчилж энэ үндсэн дээр 2028 оноос хэтрэхгүйгээр хүйсийн төлөөллийг тэнцвэржүүлэх.

Нэн тэргүүнд сонгуульд нэр дэвшүүлэх хүйсийн квотыг дээд хязгаар болгож буруугаар хэрэгжүүлж ирсэн алдааг засах, доод хязгаараас аль болохоор олон эмэгтэйг нэр дэвшүүлж ялангуяа нам ялах боломжтой тойргуудад эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх буюу бүсчилсэн байдлаар зохицуулалт хийх, улс төрийн намууд сонгуулийн зардлыг боломжит бага түвшинд байлгах, эмэгтэй нэр дэвшигчид, санхүүгийн тусгайлсан дэмжлэг үзүүлэх, улс төрийн намууд нэр дэвшүүлэхдээ төрийн албанд ажилласан туршилага, зөөлөн ур чадвар, ёс зүйн шаардлагыг гол шалгуур болгох.

Ялангуяа төрийн удирдах албан хаагч эрэгтэй эмэгтэйчүүдээс жагсаалтын эхэнд нэр дэвшүүлэхэд анхаарах, Ялангуяа төрийн албаны мерит зарчмыг улс төрийн албанд бодитоор хэрэгжүүлэх нөхцөлийг

хангах. Энэ бол яагаад энэ асуудал орж ирж байгаа вэ гэхээр энэ төрийн албаны мерит зарчим улс төрийн албанд огтын хэрэгжихгүй бүүр одоо төрийн албанаас чөлөөлж байгаа учраас цаана нь нэр дэвших боломжтой хүмүүс нь зөвхөн одоо бизнес эрхэлж байгаа хүмүүс болж байгаа. Энэнээсээ үүдээд өнөөгийн энэ одоо улс төр маань энэ төрийн алба маань тэр дундаа улс төрийн алба маань ямар болсон байгаа билээ гэдгийг бид бүхэн мэдэж байгаа. Энэ шалтгааныг арилгахад чиглэсэн ийм зөвлөмжүүд байгаа. Цаашлаад бол хүйсийн тэнцвэр хангахад чиглэсэн хэвтээ квотыг бол тойрогт цаашидаа нэр дэвшүүлэхэд ашиглах, эмэгтэйчүүдийг олноор нь нэр дэвшүүлэх нь өөрөө улс төрийн нам сонгуульд амжилт гаргах ийм хэрэгсэл болох гэсэн утгаар мөрийн хөтөлбөртөө мөн жендерийн асуудлыг тусгах, улс төрийн намын дотоод дахь эмэгтэйчүүдийн квотыг 40 хувиас дээших хэмжээнд бол тогтоох, хуульд заасан квотыг 2024 оны сонгуулиас өмнө хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийг сонгохын эсрэг явуулж байгаа хэвлэл мэдээллийн энэ буруу хэвшмэл ойлголтыг засахад чиглүүлж ялангуяа СЕХ-ноос энэ дээр хяналт тавьж ажиллах, СЕХ мөн сонгуулийн бус жилд зарцуулах санхүүжилтийг шийдвэрлэх, хэвлэл мэдээлэл төдийгүй соёл урлаг, сэтгүүл, зохиолчдын байгууллагуудын хэмжээнд жендерийн агуулга нэвтрүүлсэн бүтээгдэхүүн гаргах чиглэлд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хурлын төлөөлөгчдийн сонгуулийн хүйсийн квотыг 40-өөс 50 хувь болгон нэмэгдүүлэх замаар тэнцвэрийг хангах, улс төрийн төдийгүй бусад эдийн засгийн өмчлөлийн шийдвэр гаргалтын зэрэг тэгш байдал дээр анхаарах, Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засагт оролцоог дэмжих тухай хуулийн төслийг бол баталж мөрдүүлэх, хоёрдугаарх нь бол жендерийн эрх тэгш байдлыг хангах,

эрх зүйн бодлого, тогтолцоог боловсронгуй болгох гэсэн ийм хүрээ байгаа.

Энэ хүрээн дээр бол гаргасан зарим нэг зөвлөмжийг танилцуулъя.

Юуны өмнө 1 дүгээрт Улсын Их Хурал өөрөө өөрийгөө хүн амын хүйсийн болон бусад төлөөллийг бүрэн хангахуйц байдлаар бүрдүүлэх, энэ асуудлаар бодлого, үйл ажиллагаандаа жендерийн эрх тэгш байдлыг хангасан тусгайлсан стратеги төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, Улсын Их Хурал үндэсний хэмжээнд жендерийн тэгш байдлыг хангах механизмыг хэрэгжүүлэх асуудлаар өөрийн хийх асуудлуудыг тогтоож, асуудлуудыг төлөвлөж, тогтоож дунд хугацааны стратеги, төлөвлөгөө боловсруулж, жендерийн энэхүү одоо үнэлгээний зөвлөмжид гарсан асуудлуудыг тусган баталж хэрэгжүүлэх, НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтын 5 дугаар зорилго буюу жендерийн зорилгыг урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогодоо тусгайлан тусгаж оруулах, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэд мөн тусгах.

Тэгэхээр энэ асуудал маань өнөөдөр тусгагдаагүй байгаа гэдгийг бол зориуд хэлмээр байна. Ингээд Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг албан ёсоор зорилтот түвшинд баталгаажуулж оруулах асуудал нэн чухал байна. Мөн эмэгтэйчүүдийг алагчлах, бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилт, илтгэл, тайлан хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурлын тухай хууль тогтоомжид тусгах, мөн нэгэн чухал асуудал бол хөгжлийн бодлого төлөвлөлтийг өөрийг нь жендерийн мэдрэмжтэй болгохын тулд тухайн хуульд жендерийн үзэл баримтлалд тусган шинэчилж, хяналт шинжилгээ, үнэлгээ тайлагналтад хүйсээр ангилсан шалгуур үзүүлэлтийг тусгахаар

зохицуулах, хууль тогтоомжийг жендерийн агуулгатай болгох бол Улсын Их Хурлын нэн тэргүүний ажил байгаа. Үүнээс үүдээд хууль тогтоомжийг жендерийн агуулгатай боловсруулж хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх зарчимд шилжих, үүнээс үүдсэн жендерийн нөлөөллийн үнэлгээ хийх зохицуулалт аргачлалыг Хууль тогтоомжийн тухай хуульд өөрт нь тусгаж мөрдүүлэх, нийтийн сонсголын төрлүүд болон хяналт шалгалтын тухай асуудлуудаар хяналтын сонсголын зэрэг асуудлуудаар жендерийн эрх тэгш байдлын асуудлыг нэмж тусгаж сонсгож байх, төрийн албаны хууль тогтоомж гэдэг онцын чухал хууль тогтоомж маань өөрөө жендерийн үзэл баримтлалтай гараагүй байгаа учраас энэ хууль тогтоомжийг шинэчилж жендерийн үзэл баримтлалтай болгох, жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх дарамт хүчирхийллийг арилгахад чиглэсэн манлайлах үүргээ төрийн алба өөрөө гүйцэтгэх, төрийн албанд хүйс зааж зарлах цөөн тоотой хүйсийн хүнийг ажилд сонгон авах, энэ асуудлыг бол журамлан хуульчлах, хэрэгцээт мэргэжлээр эрэгтэй, эмэгтэй мэргэжилтнүүдийг төлөвлөх захиалгын үндсэн дээр бэлтгэдэг тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Жендерийн хууль тогтоомжид заасан 7 хүрээ байгаа. Энэ хүрээний хүрээнд тусгайлсан хууль тогтоомжуудад салбарын хууль тогтоомжуудад гэсэн үг. Энэ жендерийн эрх тэгш байдлыг хангах баталгааг нарийвчлан тусгаж жендерийн агуулгатай болгон шинэчлэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага үндсэндээ бараг тодорхойгүй шахуу байгаа.

Тийм учраас энэ төрийн албаны хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хууль

зэрэг хуулиудад бол тодорхой нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах.

Жендэрийн хуульд заасан төрийн албанд тогтоосон квотын доод хэмжээг 2024 онд багтаан биелүүлэх. Цаашид хүйсийн тэнцвэр ханга бодлого төлөвлөлтийг Улсын Их Хурлын болон Засгийн газар тусгайлан гаргах, хөдөлмөрийн үнэлэмжийг зохистой тогтоох, энэ чиглэлээр тусгай арга хэмжээ мөн хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдэд бараг бүхэлдээ ноогдож байгаа хөлсгүй хөдөлмөрийг үнэлгээжүүлэх нийгмийн байдлыг бүтээх өрхийн эдийн засагт оруулсан хувь нэмэр гэж үзэж үндэсний тооцооны систем нэвтрүүлэх, ногоон хөгжлийн болон жендерийн бодлогыг бүх бодлогын суурь болгож тогтоож бүх төрлийн, ялангуяа эдийн засаг, дэд бүтэц, уур, уурхайн бодлогуудыг ногоон бодлогод үндэслэн шинэчилж байгаль орчны ба жендэрийн үзүүлэлтийг үндсэн шалгуур болгох, хүмүүсийн оршин амьдрах анхдагч орчин болсон газар нутаг, ус ургамал, агаарын зохист нөхцөлийг хөндөхгүй байх чиглэлээр жендерийн үнэлгээ хийж, жендерийн үнэлгээгээр тооцсон үр дүнг бодлого, төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны шалгуур болгож хэрэгжүүлэх.

Дараачийн 3 дахь асуудал бол Улсын Их Хурал жендерийн үзэл баримтлал нэвтрүүлэхэд чиглэсэн хийж хэрэгжүүлэх зүйлс.

Улсын Их Хурал Хууль бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, төсөвлөх, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх бүх шатандаа жендэрийн агуулга аргачлал нэвтрүүлэх бодлогыг баталж хэрэгжүүлэх.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэг бол хамгийн чухал асуудал байгаа. Энэ төсөвлөлтийн тогтолцоог бүх шатны байгууллагад

нэвтрүүлэх талаар Сангийн яамны хийж байгаа хүчин чармайлтыг бататгаж Улсын Их Хурлаас Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид шинэчлэл хийх.

Улсын Их Хуралд жендэрийн бүлэг байгуулах жендэрийн тусгайлсан хороо байгуулах, одоо ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн бүлгийг албан болгох болон жендерийн бусад механизмын талаар зохицуулалт хийх.

Жендерийн эдгээр албан ёсны бүтцийг хүний болон санхүүгийн нөөцөөр хангах, жендерийн шинжээчдийг бэлтгэх, жендерийн үнэлгээ дүгнэлт хийдэг түүнийг Улсын Их Хурлын бодлого шийдвэрт тусгадаг эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Хууль тогтоомж, түүний төсөл, жендерийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалыг хэрэгжүүлэх, жендерийн урьдчилсан үнэлгээгээ хийгээгүй нөхцөлд Тамгын газар эрх зүйн хэлтсийн дүгнэлтээр хууль санаачлагчид буцаах зохицуулалтыг бий болгох, жендерийн нөлөөллийн үнэлгээний аргачлалд тулгуурлаад бүх хууль тогтоомжид жендерийн үнэлгээ хийж, жендерийн агуулгад тусгах жагсаалтыг гарган хэрэгжүүлэх, Жендерийн хуульд заасан жендерийн үнэлээн үнэлгээний хэрэгжилтийг Засгийн газраас шаардаж хангуулдаг байх, жендерийн дүн шинжилгээ хүйсээр ангилсан мэдээллийг нэвтрүүлэх, жендерийн статистикийн мэдээллийг боловсруулж хэрэглэх, олон нийтэд хүргэх тогтолцоог парламентын судалгаа сургалтын хүрээлэнгийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, жендерийн хуульд заасан Засгийн газрын бүрэлдэхүүн болон бусад байгууллагуудад тогтоосон квотыг хангахад бүрэн хяналт тавьж нэмэгдүүлэн тогтоож цаашид хэрэгжүүлэх, Хүний эрхийн Үндэсний Комиссын жендерийн чиглэлээрх

илтгэл, тайлан, санал, зөвлөмжийг шийдвэрт тусган хэрэгжүүлэхэд анхаарах, Жендерийн асуудлыг голлон хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн Жендерийн үндэсний хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудын жендерийн үнэлгээ дүгнэлтийг Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа бүх шатад сонсдог, хууль бодлогоддоо тусгадаг ийм зохицуулалтыг хуульчлах.

Парламентад иргэний нийгмийн оролцоо хяналтыг бий болгоход анхаарах, жендерийн нөлөөллийн түүний дотор төсвийн хөндлөнгийн үнэлгээг иргэний нийгмийн байгууллагаар хийлгэх буюу Улсын Их Хурал шийдвэртээ тусгадаг зохицуулалтыг хуульчлах.

Дөрөвдүгээрт нь, парламент дахь жендерийн мэдрэмжтэй бодлого, соёл, орчныг сайжруулахын тулд хийж хэрэгжүүлэх зүйлс.

Энэ дээр Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын буюу Тамгын газрын удирдлага албан хаагчдын жендерийн мэдлэг ойлголт хандлагыг нэн тэргүүнд дээшлүүлэх. Тэгэхээр өнөөгийн ярьж байгаа саяын ярьсан бүх зүйлс маань өөрөө энд ажиллаж байгаа удирдлага албан хаагчдын жендерийн мэдлэг хандлагаас л эцсийн эцэст шалтгаална. Тийм учраас энэ асуудал бол нэн тэргүүнд нэг номерт энд тусгагдаж байгаа. Жендэр зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал гэх эсвэл шийдвэр гаргах дээд түвшинд эмэгтэйчүүд тохирохгүй гэх жендэрийн хэвшмэл үзлээс ангижрахад чиглэсэн ийм бодлого үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх.

Улсын Их Хурлын гишүүдийн өөрийнх нь жендерийн хүсэл зориг манлайлал нэн чухал. Үүнээс үүдээд энэ асуудалд анхаарах сургалтын хөтөлбөр

тусгайлан хэрэгжүүлэх, жендерийн статистикт хүйсийн дүн шинжилгээ хийж шалтгаан үр дагаврыг тодорхойлсон чанарын үндэслэлүүдийг гаргаж, нотолгоонд суурилсан мэдээллээр Улсын Их Хурлын институцийг хангах үүргээ Парламентын сургалт судалгаа судалгааны хүрээлэнд хэрэгжүүлэх.

Ялангуяа жендэрийн статистик мэдээлэл гэхээр зөвхөн тоон мэдээллийг хэлээд түүний учир шалтгаан, чанарын үнэлгээ, дүгнэлтийн талаар тодорхой ярьдаггүй. Үүнээс үүдээд мөн одоо сөрөг ийм нөхцөл байдлууд үүсдэг. Ийм учраас тухайн асуудлыг маш энгийн ойлгомжтой байдлаар иргэд олон нийтэд хүргэдэг ийм тогтолцоог бас бий болгох. Ажилтны хөдөлмөрийг үнэлэх, цалин хөлс, урамшууллыг олгох ажлын байрны онцлогт тохирсон зохицуулалтыг хийх. Нормчлоогүй ажлын цагтай гэдгээр зөвхөн биечилсэн бүртгэлийн системд үндэслэдэг байдлыг өөрчилж, ажлын бүтээмж, ур чадвар, ажлын ачаалал, үр дүн, гүйцэтгэлд тулгуурлах байдлаар уян хатан зохицуулах аль болох илүү цагаар ажиллуулахгүй байх, ажилласан бол нэмэгдэл цалин хөлсийг бүрэн олгодог журамд зайлиггүй шилжих, ажилтны ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангах гэсэн жендерийн маш томоохон шинэлэг ойлголт байгаа.

Энэ асуудлыг бол энэ хүрээнд хэрэгжүүлэх, ажилтныхаа амьдралын нөхцөлийг судалж, бага насны, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх зэрэг онцлог хэрэгцээтэй ажилтандаа зайнаас уян хатан ажиллах тийм боломжийг хангасан гэр бүлд ээлтэй ийм ажлын байртай болох. Мөн Улсын Их Хурлын гишүүн бас бодит бус хугацаатай ийм яаралтай үүрэг даалгавар өгөх зэргээр Тамгын газрын болон бусад байгууллагын ажилтан илүү цагаар ажиллах, амралтын өдрүүдэд ажиллах ийм одоо

нөхцөл байдалд хүргэдэг учраас энэ асуудлыг Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэмд тусгах.

Улсын Их Хурлын одоо хуулиуд өөрийн зохицуулалтын хуулиуд буюу дүрэм хөдөлмөрийн дотоод журам зэрэгт жендэрийн үнэлгээ хийх шинэчлэх энэ чиглэлд бэлгийн болон бусад дарамт, ялгаварлалаас сэргийлэх, гомдол хүлээн авч шийдвэрлэх тийм тусгайлсан зохицуулалттай болох.

Улсын Их Хуралд түгээж байгаа хэвлэл мэдээлэлдээ жендэрийн үнэлгээ хийж, шалгуур үзүүлэлт мөрдөх. Сонгогчдын жендэрийн боловсролд ахиц дэвшил гаргах, хэдийгээр одоо нөхцөл байдал хүнд байгаа ч гэсэн хувцас солих болон хүүхэд хөхүүлэх өрөө, ариун цэврийн өрөө зэрэг одоо энэ бусад үйлчилгээний хэрэгцээндээ бол шинэчлэл хийх.

Улсын Их Хурал, Тамгын газар өөрийн төсвийг мөн жендэрийн үнэлгээнд тулгуурлаж ажилтны оролцоотой, ил тод жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх арга барилд шилжих. 2024 оны парламентаас эхлээд мөрдөх бодлого, хууль, журамд жендэрийн энэхүү үнэлгээнээс гарсан зөвлөмжийг бүрэн тусгаж батлах гэсэн ийм одоо зөвлөмж байна аа.

Баярлалаа.

Ц.Мөнхцэцэг: Хүний эрхийн болон жендэрийн үндэсний зөвлөхүүддээ баярлалаа.

Тэгэхээр хүний эрх жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний санал зөвлөмжтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү?

Надад 2 зөвлөхөөс тус бүр 1, 1 асуулт байгаа.

Хүний эрхийн мэдрэмжтэй парламентын үнэлгээтэй холбогдуулан хүний эрхийн 2 зөвлөх Гэрэл зөвлөх Болорсайхан нараас нөгөө тусгайлан одоо санал оруулсан байгаа. Энэ хүний эрхийн байнгын хороотой болох гээд. Энэ дээр бол энэ нөгөө 2 зөвлөхийн саналд бол одоо Байнгын хороодын дунд одоо хэлэлцэх асуудлын давхардал үүсгэхгүй үүднээс ҮХЦ-ийн болон НҮБ-ын хүний эрхийн механизмтай холбоотой асуудлуудыг хүний эрхийн Байнгын хороо тусгайлан авч хэлэлцье гэдэг санал өгсөн байна. Тэгээд энэ дээрээ бас тодруулж нэмэлт хийх нэмэлт тайлбарууд хийвэл одоо авмаар байна аа.

Ерөнхийдөө яах вэ ХЗБХ-ны одоо чиг үүрэгт хамаарагддаг одоогоор Хүний эрхийн дэд хороо. Тэгэхээр яг Хүний эрхийн байнгын хороо гэж тусгайлан байгуулбал энэ давхцалын хувьд одоо чиг үүргийн давхцал яаж гарах вэ? Энэнээс одоо сэргийлэх үүднээс энэ асуудлыг нэлээн бас дэлгэрүүлж тайлбарлаж өгнө үү гэсэн ийм асуулт байна аа.

Хоёрдугаарт нь, жендэрийн мэдрэмжтэй парламентын талаарх одоо энэ зөвлөмжтэй холбогдуулаад ерөнхийдөө энэ манай 2 зөвлөхийн энэ бүх саналууд үндсэндээ Монгол дахь одоо жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг маш өргөн хүрээтэй боловсруулагдсан гэж харагдаж байна. Яг нөгөө тухайлан одоо парламент дахь жендэрийн мэдрэмжтэй парламентын үнэлгээ, парламентыг бий болгох тухайд энэ саналуудын тодорхой хэсэг нь орсон байна аа.

Тэгэхээр энэ парламент дахь одоо жендэрийн мэдрэмжтэй байх асуудлаар эн тэргүүнд гэдэг юм уу ер нь одоо ойрын нэг 2 жилдээ яаравчлан хийх хамгийн чухал одоо саналууд нь аль вэ? Ерөнхийдөө энэ одоо 2 зөвлөхийн

маань хамгийн олон саналуудыг энэ жендерийн мэдрэмжтэй юун дээр ирсэн байна. Тухайлан яг одоо парламент Монгол Улсын Их Хурал жендерийн мэдрэмжтэй байхын тулд одоо эн тэргүүнд хийх шаардлагатай гол ажлуудыг одоо хийлгэвэл та 2 яг аль аль ажлуудыг хамгийн чухал гэж одоо үзэж байгаа вэ гэдгийг бас асууя аа.

Ингээд Үндэсний зөвлөх Болорсайхан болон одоо Гэрэл нар эхний асуултад хариулна уу.

Гуравдугаар микрофон.

Б.Болорсайхан: Зөвлөхийн зүгээс хоорондоо санал солилцсон нэг зүйл маань юу юм бэ гэхээр яг энэ жендерийн эрх тэгш байдлыг хангах, тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх гэдэг цаанаа хүний эрхийн үндсэн зарчим болох эрх тэгш байдлыг хангах, үл ялгаварлах, мөн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бодитой эдлүүлэх гээд хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхтэй холбоотой асуудлуудыг голчлон хамаарч байна аа. Тэгээд энэ дээрээ тулгуурлаад яг энэ Хүний эрхийн дэд хорооны хариуцаж байгаа өдөр тутмын үйл ажиллагаанд нь мэргэжлийн байнгын ажлын алба дэмжиж, тусалж ажиллах мөн илүү мэргэжсэн байдлаар асуудлыг гүн гүнзгий судалж танилцуулж ажиллахад бол Байнгын хорооны статус нь чухал юм байна гэж бидний зүгээс үзсэн.

Тэгээд бусад улс орны парламентын бүтцийг аваад үзэхэд бол яг салбарын асуудлыг нь яаж хуваарилж хариуцуулж байна вэ гэдэг харьцуулалт дээр тулгуурлаад энэ Үндсэн хууль, хууль зүйн үндэсний бодлогыг тодорхойлох Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг тусгайлан хариуцах. Үндсэн хуулийн цэц, парламентыг тухайлан төлөөлөх хууль

тогтоох, эрх мэдлийн хүрээнд хууль дээдлэх ёсыг чанд дагахад манлайлж ажиллах үүрэг нь энэ. Тэргүүнд Хууль зүйн байнгын хороонд нь байвал зохилтой гэж тодорхойлж томъёолж ийнхүү зөвлөмжөө буулгасан байгаа.

Хүний эрхийн байнгын хороо байгууллаа гэвэл энэ байгууллагын бүтцийн институцийн гол хариуцах зүйл нь юу байх юм бэ гэдгийг томъёолохдоо зөвлөмжид туссанчлан хүний эрх, эрх чөлөөг хангах, эдлэхүйц таатай нөхцөл боломжийг тодорхойлох, НҮБ-ын хүний эрхийн механизмд парламентын оролцоог хангах, төлөөлөх, жендерийн эрх тэгш байдал тогтвортой хөгжил зэрэг үл ялгаварлах ба эрх тэгш байх зарчмын хүрээнд хөгжих эрхийн асуудлыг Хүний эрхийн байнгын хороонд хариуцуулах гэж байгаа юм. Тэгэхээр өнөөдрийн бид нарын энэ тодорхойлсон асуудлаас гадна ирээдүйд шинэ тутам асуудал гарч ирлээ гэж үзэхэд жишээлэх юм бол хүний эрхийн үзэл баримтлал онолын хөгжлийн зүгээс аваад үзэх юм бол эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг бол хүний заавал эдлүүлэх, эдэлбэл зохих эрх гэж тодорхойлж олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хүлээн зөвшөөрч байх жишээтэй.

Тэгвэл яг энэ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн бодит биелэл ямар байна вэ, түүнд парламент хэрхэн хяналт тавих вэ гэдэг дээр бол яг энэ эрхийн асуудал талаасаа тусгайлан хариуцаж байгаа нөхцөл боломжийг тодорхойлж цаашдын урт хугацааны стратегийг зурахад гол үүрэг хүлээнэ гэдгээр нь энэ Хүний эрхийн байнгын хороо дангаар ийнхүү манлайлж ажиллах бүрэн боломжтой юм байна гэж харсан. Баярлалаа.

Ц.Мөнхцэцэг: Үндэсний зөвлөх Болорсайханд баярлалаа.

Жендерийн зөвлөхүүдээс Долгор зөвлөх үү, Батбаатар зөвлөх үү, Нэг нь хариулъя. 2 дугаар микрофон.

Б.Долгор: Баярлалаа. Тэгэхээр энэ 4 асуудал бол угаасаа дөрвүүлээ чухал байгаа. Тэр дотроосоо бол зарим нэг зүйлийг тодруулж хэлье. Мэдээж нөгөө Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх бол угаасаа нэн тулгамдсан асуудал. Угаасаа одоо ингээд сонгууль болох гэж байгаа учраас энэ сонгуульд тухайн асуудлаар их чанартай ийм үйл ажиллагаа явуулах шаардлага байгаа л даа.

Одоо ингээд томсгосон тойргоор ингээд сонгууль явагдах гэж байдаг. Тэгэхээр энэ одоо хуулиар заасан квотыг одоо хэрэгжүүлэхийн тулд улс төрийн намууд маш одоо зөв байр сууриас үнэхээр энэ эмэгтэйчүүдийг зүгээр нэг квотыг хангаж хэлбэрийн төдий нэр дэвшүүлэх биш тэднийг харин аль болохоор одоо сонгогдох боломжтой ийм одоо тойрогт дэвшүүлэх, бусад байдлаар түрүүний одоо дурдсан ялангуяа төрийн албаны туршилагатай, төрийн удирдах албанд одоо ажиллаж байгаа ийм эмэгтэйчүүдийг одоо ялангуяа жагсаалтад оруулж нэр дэвшүүлэх зэрэг энэ асуудал бол нэн тулгамдсан асуудал болчихоод байна. Энэ чиглэлээр манай одоо Хүний эрхийн дэд хороо, Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн бүлэг зөвхөн одоо тэр биш бас одоо лобби бүлэг бусад одоо бүлгүүд маань нэлээн одоо анхаарч ажиллах байх. Улсын Их Хурлын сонгууль хүртэл энэ чиглэлээр ажиллах нь чухал байна гэж ингэж хэлмээр байна.

Түүнээс гадна бол бас дараагийн орон нутгийн сонгууль хүртэл энэ орон нутгийн сонгуулийн хуулийн квотыг бол 40 хувиас доошгүй болгон тогтоох ийм шаардлага бол бас нэн тулгамдсан асуудал болж байна. Ер нь энэ

сонгуультай холбоотойгоор энэ хэвлэл мэдээллээр түгээж байгаа энэ жендерийн хэвшмэл үзлийг арилгахад чиглэсэн асуудал дээрээ бас онцгой анхаарч ажиллах шаардлагатай байх гэж.

Хоёрдугаар асуудал маань өөрөө жендерийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн бодлого, тогтолцоог боловсронгуй болгох гэж байгаа. Тэгэхээр ер нь бол одоо ингээд дараагийн сонгуулиас эхлээд шинэ парламент бүрдэж ингэж ажиллах учраас тухайн парламент яг юу юу хийх нэн тэргүүнд хийх вэ гэдгийг зайлишгүй одоогийн энэ парламент ямар нэгэн хэмжээгээр тогтоож өгнө гэж бол ойлгож байгаа. Энэнээсээ үүдээд энэ жендерийн чиглэлээрх энэ тусгайлсан төлөвлөгөө одоо баталж хэрэгжүүлэхийг бол зайлишгүй энд хэлмээр байна.

Түүнээс гадна бол Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд жендерийн үзэл баримтлалд тусгах, хууль тогтоомжийн хуульд жендерийн нөлөөллийн үнэлгээ тусгах асуудал нэн тулгамдсан асуудал байгаа. Төрийн албаны хуулийг шинэчлэх бас нэн тулгамдсан асуудал байгаа.

Дөрөвдүгээр асуудал дээр бол бас нэг зайлишгүй одоо нөгөө Улсын Их Хуралд жендерийн үзэл баримтлал нэвтрүүлнэ гэдэг нь өөрөө жендерийн бүх Улсын Их Хурлын бүх үйл ажиллагаанд л жендэрийн одоо бүтэц тогтоогдох ёстой.

Тэгэхээр Улсын Их Хуралд жендерийн бүлэг байгуулах, жендэрийн тусгайлсан хороо байгуулах.

Тэгэхээр энэ жендэрийн бүлэг жендэрийн тусгайлсан хороо гэдэг маань бол эмэгтэйчүүдийн бүлгээс өөр шүү дээ тийм ээ. Одоогийнхыг хүртэл бас хэрэгжүүлж ирсэн энэ лобби бүлэг

гээд энэ бүлгүүд маань бол их чухал ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ жендерийн асуудлыг тусгайлан авч үздэг. Жендерийн асуудлаар.

Ц.Мөнхцэцэг: Үндэсний зөвлөх Долгор танд баярлалаа.

Ингээд хүний эрх, жендэрийн асуудлаарх парламентын үнэлгээний санал, зөвлөмжтэй холбоотойгоор үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Үг хэлэх гишүүд алга.

Тэгэхээр Хүний эрхийн дэд хорооноос олон улсын парламентын өөрийн үнэлгээтэй холбогдуулан гарах тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28.4-д заасны дагуу Дэд хороо тухайн эрхэлсэн асуудлаараа хяналт, шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авах, ажлын хэсэг байгуулах эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж харьяалах Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй.

Ингээд та бүхэнд энэ тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны тогтоол

Санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.11 дэх хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь:

1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дарга Д.Энхбатад даалгасугай.

1. Монгол Улсын Их Хурал Түүний Тамгын газарт хийсэн хүний эрх жендерийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний санал зөвлөмжид дүн шинжилгээ судалгаа хийсний үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах,

2. Улсын Их Хурал түүний Тамгын газрын стратеги төлөвлөгөөнд өөрийн үнэлгээнээс гаргасан санал зөвлөмжийг тусгах асуудлыг судалж шийдвэрлэх тэдгээрийн үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллах,

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хүний эрхийн дэд хороо Ц.Мөнхцэцэгт даалгасугай.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Сүхбаатар гишүүнээр тасалъя.

Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Нэгдүгээрт тэр яах вэ найруулгын чанартай юм байна аа. Тэр 1.2-ын заалт байна шүү дээ. Тэр стратеги төлөвлөгөөнд өөрийн үнэлгээнээс гаргасан санал, зөвлөмжийг тусгах асуудлыг судалж шийдвэрлэх гэж байна шүү дээ. Нэг их сүртэй тэгээд байх хэрэггүй шүү дээ. Та хэд үнэхээр тийм санал зөвлөмж нь хэрэгтэй тийм стратеги, төлөвлөгөөнд ороогүй юмыг оруулчихсан л юм бол судлаад байх хэрэггүй зүгээр тусгах гээд тавьчих. Тийм тэр чинь тусгачих л хэрэгтэй байхгүй юу. Тэрнээс тэрийг судлаад л шийдвэрлэнэ гээд ингээд яах хэрэггүй. Зүгээр тусгах гээд тавьчих.

Хоёрдугаарт Монгол Улсын Их Хурал гээд Улсын Их Хурлыг 2 янзаар биччихсэн байна шүү дээ. 1, 2 дугаар заалт дээр. Монгол Улсын Их Хурал, Улсын Их Хурал гээд. Тэгээд энэ найруулгаа нэг тавьчихъя. Тэгээд 2 заалт дээр хоёулан дээр нь тэгээд нэг нь Энхбатад даалгаад, дараагийнх нь тогтоол дээр хяналт тавих гэдгээр нь яасан юм уу тэ? Тэгвэл тэгээд бусад нь болж байх шиг байна.

Ц.Мөнхцэцэг: “Санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Хүн хүний эрхийн дэд хорооны тогтоолын төслийг

баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Тэгэхээр санал зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай хүний эрхийн дэд хорооны тогтоол тогтоолын төсөл батлагдлаа.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

15.11 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*